



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын төсвийн
багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит*

Аудитын код: УАГ-САГ/2015/06/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот
2015 оны 4 дүгээр сар



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын
газрын дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 260512
Цахим хаяг:
oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Юра
Утас: 263813
yurag@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр
Бага тойруу 3
Улаанбаатар-15160
Монгол Улс

Цахим хаяг: www.audit.mn

2015 оны 4 дүгээр сар

АГУУЛГА

АУДИТЫН ТАЙЛАН

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
Байгууллагын хууль, эрх зүйн орчин
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн
горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний
үр дүн
Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар
Дотоод хяналт
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх
тайлбар
Шилэн дансны мэдээлэл
Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
Гол, онцлог гүйлгээний талаар
Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар
Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын тайлбар
Анхаарал татахуйц бусад чухал асуудал
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн
нэгтгэл
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Зөвлөмж
Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Аудитын гэрчилгээ

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /ҮАГ-САГ/2015/06/СТА-ТЕЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 05-наас 2015 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын ахлах аудитор Г.Юра хэрэгжүүлэв.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагууд үйл ажиллагаандаа Байгаль орчныг хамгаалах тухай, Байгалийн ургамлын тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай, Ойн тухай, Амьтны тухай, Агаарын тухай, Усны тухай, Хог хаягдлын тухай зэрэг салбарын онцлог хууль эрхийн актуудыг мөрдөн ажиллаж байна.

Түүнчлэн санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж байна. Тайлант

онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Аудитын явцад төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны эрхэм зорилго нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2-т заасны дагуу Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

БОНХАЖ-ын яам нь дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- Төрийн захиргааны удирдлагын газар;
- Ногоон хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газар;
- Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар;
- Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар;
- Тусгай хамгаалттай нутгийн удирдлагын газар;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;
- Газар зохион байгуулалт болон усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар;
- Ойн бодлого зохицуулалтын газар.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд нийслэл, аймаг орон нутгийн УЦУОШГазар түүний харьяа нийт 27 салбар нэгж, Тусгай хамгаалалттай газрын захиргаа, Байгалийн цогцолборт газар, дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны нийт 30 байгууллага, Сав газрын захиргааны 26 байгууллага, яамны аппарат, хөрөнгө оруулалт, ойжуулалт, ойн арга хэмжээний болон төвлөрсөн арга хэмжээний зардал, Үндэсний хороо-5, Засгийн газрын тусгай сан-2, УТҮГ-2, тус яаманд хэрэгждэг 4 төсөл хөтөлбөр зэрэг нийт 100 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн болно.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн

санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 11 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны нийт зардлын 1 хувиар тооцож 766.6 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В-1/

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд /хуучин нэрээр/-ын 2009 оны 365 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын нэгтгэлийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “дунд” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тайлант хугацаанд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын санхүүгийн бүртгэлийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл бүхий санхүү, нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програмаар хөтөлж, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан байна.

Дотоод хяналтын талаар

БОНХАЖЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрыг тус яамны ТНБД-ын 2014 оны А-07 дугаар тушаалаар 6 орон тоотой /А-322 дугаар тушаалаар 8 орон тоогоор ажиллаж байгаа/-гоор байгуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн шууд удирдлагад ажиллуулж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар БОНХ /хуучин нэрээр/-ийн сайд, Дотоод аудитын хорооны даргын баталсан “Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны төсвийн дотоод аудитын 2014 оны төлөвлөгөө”-г үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан байна.

Төлөвлөгөөний дагуу 2014 онд харьяа 13 байгууллагын 2013 оны төсвийн төлөвлөлт, зарцуулалт, бүртгэл тайлагналын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт зөвлөмж өгч ажилласан бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 84.0 хувийн биелэлттэй байна. Үүнд:

- БОНХЯ-ны аппарат, Байгаль хамгаалах сан, ЦУОШГ, Туул голын сав газрын захиргаа, Цэнгэг усны нөөц Байгаль хамгаалах төв, Дорнод, Богд хан уул, Говийн Их, бага Дархан цаазат газрын Хамгаалалтын захиргаа, Дарьганга, Горхи тэрэлж, Их богд, Монгол элсний Байгалын цогцолборт газрын хамгаалалтын захиргаа зэрэг байгууллагууд хамрагджээ.

Түүнчлэн БОНХЯ-ны ТНБД-ын 2014 оны А-271 дүгээр тушаалаар яамны Өмч хамгаалах байнгын зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулж байна.

Зөвлөл нь зохих хууль тогтоомжийн дагуу өмч хөрөнгийн асуудлаар санал дүгнэлт гаргаж холбогдох материалыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтийг тооцох, тайлагнах ажлыг удирдан зохион байгуулах үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар

Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны төсвийг нийт 74,939.7 сая төгрөгөөр баталснаас төсвийн тодотголоор 6,371.4 сая төгрөгөөр буурч, 68,568.3 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 61,062.8 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 10.9 хувиар буюу 7,505.5 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

Төсвийн санхүүжилтийн эх үүсвэрээр авч үзвэл улсын төсвөөс 57,308.4 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 145.6 сая, гадаадын тусламжаас 3,155.9 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 858.9 сая, хүүгийн орлогоос 1.8 сая, оны эхний үлдэгдлээс 1.7 сая төгрөг тус тус авч зарцуулсан байна.

Тайлант онд нийт 2,899 орон тоотой ажиллахаас 2,895 орон тоогоор ажилласан байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг БОНХАЖ-ын яаманд хэрэгжүүлэх зорилгоор ТНБД-ын 2015 оны 1 дүгээр тушаалаар “Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны шилэн дансны тухай журам”-ыг батлан хэрэгжилтийг зохион байгуулж, шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны www.mne.gov.mn цахим хуудсууд болон яамны "Шилэн данс" мэдээллийн самбарт холбогдох мэдээллүүдийг байршуулсан байна.

Шилэн дансны цахим хуудсанд дараах 53 мэдээ мэдээллийг байршуулжээ. Үүнд:

Мэдээллийн нэр төрөл	Оруулсан мэдээний тоо
Төсвийн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт, гүйцэтгэл	9
Төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт	2
Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессийн зүйлийн зарлага, санхүүжилт /төлөвлөгөө/	4

Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа	1
Төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт /гүйцэтгэл/	7
Тендерийн ерөнхий мэдээлэл	11
Цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ	16
Шийдвэрийн жагсаалт	3

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу тогтоосон эрсдэл, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэсэн болно.

Гол, онцлог гүйлгээний талаар

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүн бүхий дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

2014 онд ойжуулалт, ойн арга хэмжээний зардлаас 2,065.2 сая төгрөгийн дараах томоохон арга хэмжээний зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Ойн зурвас байгуулах ажилд 394.8 сая, ойжуулалтын ажилд 33.2 сая, заг тарих ажлын санхүүжилтэд 283.8 сая, ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажилд 233.4 сая, Ойн судалгаа хөгжлийн төвд эрх шилжүүлэхэд 1,120.0 сая төгрөг зарцуулсан.
- Түүнчлэн төвлөрсөн арга хэмжээний зардлаас Ойн тооллого явуулахад 624.1 сая, тэмдэг, тэмдэглэгээний ажилд 442.7 сая, цоохор ирвэсний популяцийн судалгаа явуулахад 17.0 сая, симпозиум, Ази номхон далайн бүсийн 32 дугаар бага хуралд нийт 52.5 сая, Богдхан уулын аяллын замыг тэмдэгжүүлж, хаягжуулах ажилд 50.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

БОНХАЖС-ын 2015 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А-93, А-102, А-103 дугаар тушаалаар Ерөө, Хараа, Орхон, Чулуут, Онги, Таац голын Сав газрын захиргаадыг 2015 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөр татан буулгаж, Хараа-Ерөө голын, Онги-Таац голын, Орхон-Чулуут голын Сав газрын захиргаа болгон нэгтгэн зохион байгуулсан байна.

Аудитаар илрүүлсэн гол зүйлс, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитын явцад Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал,

ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлагналын талаар

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан журам, аргачлалын дагуу бэлтгэж тайлагнасан байна.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд /БОНХАЖС/ 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 1/1904 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 100 салбар нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд нийт төсвийн багцын 62.7 хувьд нь Үндэсний аудитын газар, 28.0 хувьд нь аймаг, орон нутгийн Аудитын газар, 7.4 хувь буюу 15 байгууллагын санхүүгийн тайланд Хараат бус аудитын компаниуд тус тус аудит хийж дүгнэлт өгсөн болно.

БОНХАЖ-ын сайдын төсвийн багцын 1.9 хувийг эзлэж байгаа Дархан-Уул аймгийн УЦУОШАлба, Хангайн нуруу, Монгол Алтайн нуруу, Хөх сэрхийн нуруу, Тужийн нарсны БЦГ-ууд болон Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн гэж итгэл үзүүлэн, аудитад хамруулахгүйгээр “зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар БОНХАЖ-ын сайдын төсвийн багцын 98.5 хувь буюу 96 байгууллагын санхүүгийн тайланд “зөрчилгүй”, 1.5 хувь буюу Говийн их ДЦГ-ын “А” хэсэг, Увс нуурын ай сав газар, Богд хаан уулын Хамгаалалтын захиргааны санхүүгийн тайланд “хязгаарлалттай”, Говийн их ДЦГ-ын “Б” хэсгийн санхүүгийн тайланд “сөрөг” дүгнэлт тус тус өгсөн байна.

БОНХАЖС-ын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тус яаманд хэрэгждэг 4 төслийн санхүүгийн тайлан санхүүжүүлэгч байгууллагын журмын дагуу цаг хугацааны зөрүүтэйгээс шалтгаалан аудит хийгдэхгүйгээр нэгтгэгдсэн болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 969.1 сая төгрөг мөнгөн хөрөнгө, 9,815.6 сая төгрөг /үүнээс Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн авлага 9,677.1 сая төгрөг/-ийн авлага, 5,516.0 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардал, 9,041.3 сая төгрөгийн өглөг, 5,738.4 сая төгрөгийн бараа материал, 34,965.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны эцэст бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг хийж, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн харилцагч банкуудтай тооцоо нийлж баталгаажуулсан байна.

- БОНХАЖ-ын сайдын төсвийн багцын төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчдын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан томилолт, шатахууны зардлын зарим ажил гүйлгээг бүрдэл дутуу баримтаар бүртгэж тайлагнасан, баримтад ажил гүйлгээтэй холбоогүй баримтууд хавсаргасан, ажил үйлчилгээний төлбөр тооцоог илүү тооцох, авлагаар бүртгэхгүй орхигдуулах, бараа материалын худалдан авалтыг авлага, бараа материалын тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн, үндсэн хөрөнгө, бараа материалыг буруу ангилж бүртгэсэн, тооллогын бүртгэлээс зөрүүтэй тайлагнасан, хөрөнгө оруулалтаар шилжүүлсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй, батлагдсан төсвийг ангилал хооронд зөрүүлэн бүртгэсэн зэрэг зөрчил дутагдлын улмаас нийт 510.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, аудитын явцад 342.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулсан байна.

Энэ нь БОНХАЖ-ын яамны системийн байгууллагуудын жилийн эцсийн санхүүгийн тайланг *“Тойрох хуудас”*-гүйгээр Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүлээн авч байгаагаас шалтгаалан тухайн байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгын иж бүрдэл, батлагдсан орон тоо, төсөв, тэдгээрийн гүйцэтгэл, авлага, өр төлбөрийн баталгаажилт, мөнгөн хөрөнгө, үнэт цаас тооцоот маягт, бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого тооцоо, хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, хөрөнгө оруулалт, өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, тайлант оны аудитын тайлан дүгнэлт, мөн яамны Дотоод аудитын шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт зэрэгт тавих хяналт сул байгааг харуулж байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт хийж, акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллахыг БОНХАЖ-ын яамны удирдлагад зөвлөмж болгох.

БОНХАЖ-ын яамны системийн хэмжээний санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа “Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг /НБББББ/-ийг шинэчлэн боловсруулахаар Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн 2015 оны төлөвлөгөөнд тусгасан байна.

Шинээр боловсруулах НБББББ-т тус яамны системийн байгууллагуудын үйл ажиллагааны онцлогтой холбоотой нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналт, шинээр батлагдсан хууль эрхийн акт, заавар журам, стандартыг хэрхэн дагаж мөрдөх болон дээр дурдсан асуудлыг тусгах нь зүйтэй байна.

Засгийн газрын тусгай сангийн талаар:

Тус яаманд хэрэгжиж байгаа Байгаль хамгаалах сан, Цэвэр агаарын сангийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар аудит хийж бие даасан дүгнэлт, зөвлөмж өгсөн бөгөөд аудитаар илэрсэн зөрчил дутагдал, зөвлөмжийг БОНХАЖ-ын яамны сайд, удирдлагуудын анхааралд хандуулах шаардлагатай тул энэхүү тайланд бүрэн эхээр нь татан танилцуулж байна.

1. Байгаль Хамгаалах сан:

- Байгаль Хамгаалах сан нэр бүхий 11 ААН, байгууллагатай холбоотой 54.8 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, “Геомастер” ХХК-тай холбоотой 2013 оны үлдэгдэл 150.0 сая төгрөгийг тайлан балансад өглөгөөр бүртгээгүй, НДШ төлөлтийн тайлангийн үлдэгдлээс 7.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,

- Гадаад албан томилолтын тайлан тооцоонд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, тооцоог хугацаанд нь, нотлох баримтаар хийдэггүйгээс 2014 онд нэр бүхий 7 хүнтэй холбоотой нийт 6.9 сая төгрөгийн томилолтын зардлыг анхан шатны баримтгүйгээр шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн,
- Байгаль хамгаалах сангийн захирлын 2013 оны 01 дүгээр тушаалаар тус сангийн ажиллагсдын цалингийн хэмжээг тогтоохдоо Засгийн газрын 2012 оны 78 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтаар баталсан цалингийн жишиг хэмжээнээс 40-55 хувиар нэмэгдүүлэн, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5-25 хувиар тооцож шинээр ажилд орсон ажилчдад ур чадварын нэмэгдлийг 25 хувиар тус тус олгосон байна.

Дээр дурдсан зөрчлийг арилгах зөвлөмжийг Байгаль хамгаалах сангийн удирдлагад өгсөн бөгөөд БОНХАЖ-ын сайдын анхааралд хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

2. Цэвэр агаарын сан:

- Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо /АББҮХ/-ны 2011.05.26-ны өдрийн 11/05 дугаар тогтоолоор нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний их багтаамжийн автобусуудад дизель түлш болон шингэрүүлсэн нефтийн хийн хосолмол хэрэглээг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэхийг ЗТЯ, БХБЯ болон Цэвэр агаарын санд даалгажээ. Энэхүү шийдвэрийн дагуу холбогдох байгууллагууд ажлыг эхэлж нийт 3,380.0 сая төгрөгийн 400 ширхэг төхөөрөмж нийлүүлж, 2011-2012 онд санхүүжилтийг 90 хувь олгожээ. Гэтэл өнөөг хүртэл хугацаанд ажлын гүйцэтгэл 62.5 хувийн гүйцэтгэлтэй, ажил зогссон байна.
- БОНХЯ /хуучин нэрээр/-ны ТНБД-ын 2013 оны А/52 дугаар тушаалаар “Хаштехник” ХХК-тай авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт хий, утааны тортогжилтыг бууруулах төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах гэрээ байгуулах шийдвэр гаргажээ. Үүний дагуу гэрээ байгуулж нийт 830.0 сая төгрөгөөс 747.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна. Тус компани нь гэрээний дагуу 2510 автомашинд утаа бууруулах төхөөрөмж суурилуулахаас 1658-ыг сурилуулсан, одоогийн байдлаар ажил зогссон, гэрээний гүйцэтгэлийг дүгнэх ажлын хэсгийг ЗТЯ-тай хамтран ажиллуулсан боловч дүгнэлт эцэслэн гараагүй байна.
- “Дашваанжил” ХХК-тай 2012 онд тус сантай хийсэн автомашиныг хийгээр цэнэглэх станц байгуулах гэрээний биелэлтийг үзэхэд суурин 4, зөөврийн 4, нийт 8 станц байгуулахаас суурин 4-ийг байгуулж улсын комисст хүлээлгэн өгч, зөөврийн 4 станцын газрын асуудлыг шийдвэрлээгүйгээс улсын комисс хүлээн аваагүй байна.

Эдгээр асуудлыг Цэвэр агаарын сангийн санхүүгийн тайлангийн аудитаар БОНХАЖ-ын сайд, Зам тээврийн сайд, АББҮХ-ны дарга, Цэвэр агаарын сангийн Удирдах зөвлөлд тус тус зөвлөмж болгосон бөгөөд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зөвлөмжид тусгах нь зүйтэй гэж үзсэн болно.

Авлагын талаар:

БОНХАЖЯамны системийн хэмжээнд 2013 оны эцэст 595.0 сая төгрөгийн авлагатай байсан бол 2014 оны эцэст 138.5 сая төгрөг болж өмнөх оноос 456.5 сая төгрөгөөр буурсан байна.

БОНХАЖ-ын сайдын төсвийн багцын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд жилийн эцэст Төв төрийн санд татан төвлөрүүлсэн нэр бүхий 15 байгууллагын нэмэлт төсвийн дансны үлдэгдэл нийт 9,677.1 сая төгрөгийг авлагаар тусгаагүй байсныг “Үлдэгдэл буцаан олгох тухай” Сангийн сайдын 2015 19, 55, 92 дугаар тушаалаар баталсан “Зарцуулах эрх нь 2015 төсвийн жилд дамжин хэрэгжих нэмэлт төсвийн дансны үлдэгдлийг буцаан олгох байгууллагуудын жагсаалт”-ыг үндэслэн аудитын явцад авлагаар тусгуулан холбогдох залруулгыг хийлгэсэн болно.

Урьдчилж төлсөн зардлын талаар:

Тайлант оны эцэст урьдчилж төлсөн зардал дансанд 5,516.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсанаас Цэвэр агаарын сангийн 4,384.1 сая, Байгаль хамгаалах сангийн 633.8 сая, БОНХАЖ-ын яамны хөрөнгө оруулалтын 289.8 сая, бусад 208.3 сая төгрөгийн зардал бүртгэгдэж байна.

Бараа материалын талаар:

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны бараа материалын эхний үлдэгдэл 5,619.0 сая төгрөг байсан бол тайлант онд 119.1 сая төгрөг буюу 2.1 хувиар өссөн байна. Тайлант онд 6,806.4 сая төгрөгийн худалдан авалт хийж, үүнээс шаардах хуудсаар 6,744.6 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Нийт бараа материалын эцсийн үлдэгдэлд тусгай зориулалтын материал 30.5 хувь, аж ахуйн материал 27.7 хувь, бусад хангамжийн материал 25.1 хувь, мал амьтад 1.6 хувь, бичиг хэргийн материал 2.2 хувь, сэлбэг хэрэгсэл, түлш шатах тослох болон бусад материал 12.9 хувийг тус тус эзэлж байна.

2014 онд 1,618.0 сая төгрөгийн бараа материалыг хандив тусламжаар авсан хөрөнгөөр бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

Хөрөнгийн байршил /байгууллагаар/	Дүн /сая төг./	Хөрөнгийн эх үүсвэр
Цаг уур орчны шинжилгээний газар	1,380.7	Олон улсын эрдэм шинжилгээний ажлын төслөөс санхүүжсэн.
Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв	1.9	Монгол орны тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх /SPAN/ төслөөс санхүүжсэн
Ойн судалгаа хөгжилийн төв	118.2	Монгол-Солонгосын “Ногоон хэрэм төсөл”-өөс санхүүжсэн.
УТХГ-ын хамгаалалтын захиргаа	117.2	Монгол орны тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх /SPAN/ төслөөс санхүүжсэн.

Тайлант онд хөрөнгө оруулалтаар өгсөн бараа материалын 75.5 сая төгрөгийг шилжүүлэн авсан хөрөнгөөр, 86.1 сая төгрөгийг бусад бараа материалын орлогоор, 2,749.3 сая төгрөгийн бараа материалыг салбар хооронд шилжүүлэн бүртгэж тайлагнасан байна.

Үнэт цаас, тооцоот маягтын талаар:

Аудитаар тус яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, тооцоот маягтыг тоолж, хадгалалт хамгаалалт, бүртгэл тайлан тооцоог шалгаж үзэхэд нийт 17 төрлийн үнэт цаас, тооцоот маягт байгаагаас тооллогоор бичигдээгүй 10 төрлийн 2007 ширхэг буюу нийт 5,677.9 мянган төгрөгийн маягтын үлдэгдэлтэй, 5 төрлийн 343.2 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 104 ширхэг маягт бичигдсэн боловч холбогдох байгууллага, хүмүүс нь аваагүй, 10 төрлийн 324 ширхэг буюу 577.1 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий маягт хүчингүй болсон байна.

Дээрх маягтуудыг бараа материалын бүртгэлд бүртгэж тайлагнаагүй, яамны Нэг цэгийн үйлчилгээний ахлах мэргэжилтэн хариуцан ажиллаж байна.

Шийдвэрлэсэн нь: Үнэт цаас, тооцоот маягтыг аж ахуйн нярвын хариуцлагад шилжүүлэн, бараа материалын дансанд бүртгэж, шаардах хуудсаар зарцуулан, тайлан тооцоонд тавих дотоод хяналтын үр нөлөөг сайжруулж ажиллах талаар яамны удирдлагад зөвлөмж болгох.

Үндсэн хөрөнгийн талаар:

Үндсэн хөрөнгө оны эхэнд 52,549.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байснаас 2014 онд Төрийн өмчийн хорооны 2014 оны 373, 628 дугаар тогтоол, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын шийдвэр, Улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн бүтцийн өөрчлөлтөөр 3,529.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, 36.5 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 635.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлаж данснаас хассан, 29.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж худалдсан байна.

Тайлант онд БОНХАЖ-ын сайдын төсвийн багцын хөрөнгө оруулалтаар нийт 4,514.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

Өр төлбөрийн талаар:

БОНХАЖ-ын сайдын төсвийн багцын дүнгээр 2014 оны эцэст 9,041.3 сая төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсанаас нөхөн сэргээлтийн баталгааны олгогдоогүй өглөг 6,904.6 сая, хөрөнгө оруулалтын өглөг 8.4 сая, ажиллагсадтай холбоотой өглөг 15.0 сая төгрөг, бараа, үйлчилгээний зардлын тооцооны өглөг 15.4 сая төгрөг, байгууллагатай холбоотой бусад өглөг 2,097.9 сая төгрөг бүртгэгдсэн байна.

Орлогын талаар:

Тайлант онд нийт 79,719.3 сая төгрөгийн орлоготой ажилласан бөгөөд дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Орлогын төрөл зүйл	Дүн	Дүнд эзлэх
--------------------	-----	------------

		хувь
Урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн	51,608.7	64.6
Тусгай зориулалтын сангийн орлого	1,011.4	1.3
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого	4.8	-
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжийн	4,225.2	5.3
Засгийн газрын болон Засаг даргын нөөц хөрөнгөнөөс	139.5	0.2
Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого	3,287.2	4.1
Төсвийн урамшууллын орлого	122.8	0.2
НДСангийн шилжүүлгийн орлого	95.8	0.1
Нэмэлт санхүүжилтийн орлого	2,293.6	2.9
НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс	3,285.6	4.1
Хөрөнгө оруулалтын орлого	6,887.4	8.6
Чехийн Хөгжлийн агентлагаас	18.1	-
Дэлхийн байгаль хамгаалах сангаас	30.2	-
Орон нутгийг хөгжүүлэх сангаас	5.7	-
Төвлөрсөн арга хэмжээнээс дахин хуваарилсан	390.1	0.5
Бусад үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,514.5	8.1
Нийт дүн	79,920.6	100.0

Зардлын талаар:

Тайлант онд БОНХАЖ-ын сайдын төсвийн багцын дүнгээр үйл ажиллагааны зардалд 73,505.5 сая үйл ажиллагааны бус зардалд 3,348.0 сая төгрөг зарцуулсан байна.

Үйл ажиллагааны зардлын 51.7 хувийг урсгал үйл ажиллагааны зардал, 36.6 хувийг ажиллагсдын зардал, 7.2 хувийг хөрөнгө оруулалтын зардал, 2.8 хувийг туслаж шилжүүлгийн зардал, 0.8 хувийг нийгмийн хамгааллын зардал, 0.9 хувийг бусад зардал эзлэж байна.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар санхүүгийн тайланд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүнгээр системийн хэмжээнд 8.2 сая төгрөгийн 17 акт, 38.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 8 албан шаардлага тогтоогдож, 463.1 сая

төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 90 зөвлөмж өгөгдөж, нийт 510.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 342.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулсан байна.

Аудитаар илэрсэн бүх асуудлыг БОНХАЖ-ын яамны удирдлага авч үзэж, судлан шийдвэрлэхээр хүлээн зөвшөөрч, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаар тохиролцсон тул материаллаг алдаагүй гэж үзлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Үндэсний аудитын газар болон нийслэл, орон нутгийн аудитын байгууллагаас БОНХС-ын төсвийн багцын шууд болон төвлөрүүлэн захирагчдын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 75 зөвлөмж өгснөөс 8 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу 89.3 хувийн биелэлттэй байна.

БОНХС-ын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 4 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 1/4920 дугаар албан бичгийн хамт Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Зөвлөмж

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 6 зөвлөмж өгч, Менежментийн захидалд тусгасан болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Бид Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудитор санал болгож байна.



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 2 зүйлс:

Асуудал 1, 2, 3

Цэвэр агаарын сангийн тайлан
тооцооны талаар

Асуудал 4, 5

Санхүүгийн тайлан тоцооны
талаар

Асуудал 6

Үнэт цаас, тооцоот маягтын
бүртгэл, тайлагналын талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь АОУС-ын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмжүүд дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, харьяа байгууллагуудын санхүүгийн болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал:

- Цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлууд;
- Удирдлагын анхаарах шаардлагатай асуудлууд;

Асуудал 1 Цэвэр агаарын сангийн тайлан тооцооны талаар	Тэргүүлэх ач холбогдол № 2
--	----------------------------

ҮАГ-ын ажиглалт

Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо /АББҮХ/-ны 2011.05.26-ны өдрийн 11/05 дугаар тогтоолоор нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний их багтаамжийн автобусуудад дизель түлш болон шингэрүүлсэн нефтийн хийн хосолмол хэрэглээг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэхийг ЗТЯ, БХБЯ болон Цэвэр агаарын санд даалгажээ. Энэхүү шийдвэрийн дагуу холбогдох байгууллагууд ажлыг эхэлж нийт 3,380.0 сая төгрөгийн 400 ширхэг төхөөрөмж нийлүүлж, 2011-2012 онд санхүүжилтийг 90 хувь олгожээ. Гэтэл өнөөг хүртэл хугацаанд ажлын гүйцэтгэл 62.5 хувийн гүйцэтгэлтэй, ажил зогссон байна.

ҮАГ-ын зөвлөмжүүд

АББҮХ-ны дарга болон ЗТЯ-ны сайдад:

Өмнө гарсан шийдвэрийг эргэн хянаж ашиглалтын талаас эцсийн шийдвэрийг гаргаж үйлчилгээнд нэвтрүүлэх цогц арга хэмжээ авах;

Зөвлөмжийн биелэлтийг 2015 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Үйлчлүүлэгчийн хариу

Сангийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зарчим алдагдах, үргүй зардал гаргах;

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ҮАГ-ын ажиглалт

БОНХЯ /хуучин нэрээр/-ны ТНБД-ын 2013 оны А/52 дугаар тушаалаар “Хаштехник” ХХК-тай авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт хий, утааны тортогжилтыг бууруулах төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах гэрээ байгуулах шийдвэр гаргажээ. Үүний дагуу гэрээ байгуулж нийт 830.0 сая төгрөгөөс 747.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна. Тус компани нь гэрээний дагуу 2510 автомашинд утаа бууруулах төхөөрөмж суурилуулахаас 1658-ыг сурилуулсан, одоогийн байдлаар ажил зогссон, гэрээний гүйцэтгэлийг дүгнэх ажлын хэсгийг ЗТЯ-тай хамтран ажиллуулсан боловч дүгнэлт эцэслэн гараагүй байна.

Эрсдэлүүд

Сангийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зарчим алдагдах, үргүй зардал гаргах;

ҮАГ-ын зөвлөмжүүд

БОНХАЖ-ын сайдад:

Мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл оролцуулсан ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, уг төхөөрөмжийн үр өгөөжийн талаар бүх ашиглагч байгууллагуудаас санал асуулга авч, төслийн хөрөнгийг цаашид санхүүжүүлэх эсэх талаар дүгнэлт гаргуулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2015 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ҮАГ-ын ажиглалт

“Дашваанжил” ХХК-тай 2012 онд тус сантай хийсэн автомашиныг хийгээр цэнэглэх станц байгуулах гэрээний биелэлтийг үзэхэд суурин 4, зөөврийн 4, нийт 8 станц байгуулахаас суурин 4-ийг байгуулж улсын комисст хүлээлгэн өгч, зөөврийн 4 станцын газрын асуудлыг шийдвэрлээгүйгээс улсын комисс хүлээн аваагүй байна.

ҮАГ-ын зөвлөмжүүд

БОНХАЖ-ын сайдад:

Зөөврийн 4 станцыг хүлээн авч улсын комиссын акт гаргуулах, 2 станцын газрын асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

Зөвлөмжийн биелэлтийг 2015 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Сангийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зарчим алдагдах, үргүй зардал гаргах;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ҮАГ-ын ажиглалт

БОНХАЖ-ын сайдын төсвийн багцын төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчдын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан томилолт, шатахууны зардлын зарим ажил гүйлгээг бүрдэл дутуу баримтаар бүртгэж тайлагнасан, баримтад ажил гүйлгээтэй холбоогүй баримтууд хавсаргасан, ажил үйлчилгээний төлбөр тооцоог илүү тооцох, авлагаар бүртгэхгүй орхигдуулах, бараа материалын худалдан авалтыг авлага, бараа материалын тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн, үндсэн хөрөнгө, бараа материалыг буруу ангилж бүртгэсэн, тооллогын бүртгэлээс зөрүүтэй тайлагнасан, хөрөнгө оруулалтаар шилжүүлсэн хөрөнгийг бүртгэлд тайланд тусгаагүй, батлагдсан төсвийг ангилал хооронд зөрүүлэн бүртгэсэн зэрэг зөрчил дутагдлын улмаас нийт 510.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, аудитын явцад 342.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулсан байна.

Энэ нь БОНХАЖ-ын яамны системийн байгууллагуудын жилийн эцсийн санхүүгийн тайланг *“Тойрох хуудас”*-гүйгээр Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүлээн авч байгаагаас шалтгаалан тухайн байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгын иж бүрдэл, батлагдсан орон тоо, төсөв, тэдгээрийн гүйцэтгэл, авлага, өр төлбөрийн баталгаажилт, мөнгөн хөрөнгө, үнэт цаас тооцоот маягт, бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого тооцоо, хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, хөрөнгө оруулалт, өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, тайлант оны аудитын тайлан дүгнэлт, мөн яамны Дотоод аудитын шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт зэрэгт тавих хяналт сул байгааг харуулж байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих дотоод хяналт, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай удирдах зарчим алдагдах, үргүй зардал гаргах;

ҮАГ-ын зөвлөмжүүд

Аудитаар илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт хийж, акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах;

Зөвлөмжийн биелэлтийг 2015 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ҮАГ-ын ажиглалт

2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар Говийн их ДЦГ-ын “А” хэсэг, Увс нуурын ай сав газар, Богд хаан уулын Хамгаалалтын захиргааны санхүүгийн тайланд “хязгаарлалттай”, Говийн их ДЦГ-ын “Б” хэсгийн санхүүгийн тайланд “сөрөг” дүгнэлт тус тус өгсөн байна. Энэ нь БОНХАЖ-ын сайдын төсвийн багцын 1.5 хувийг эзэлж байна.

ҮАГ-ын зөвлөмжүүд

Санхүүгийн тайлангийн аудитаар “хязгаарлалттай”, “сөрөг” санал, дүгнэлт авсан байгууллагуудын холбогдох албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 28.1-д заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, хариуцлага тооцох арга хэмжээ авч ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2015 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт алдагдах, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд сөрөг нөлөө үзүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ҮАГ-ын ажиглалт

Аудитаар тус яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, тооцоот маягтыг тоолж, хадгалалт хамгаалалт, бүртгэл тайлан тооцоог шалгаж үзэхэд нийт 17 төрлийн үнэт цаас, тооцоот маягт байгаагаас тооллогоор бичигдээгүй 10 төрлийн 2007 ширхэг буюу нийт 5,677.9 мянган төгрөгийн маягтын үлдэгдэлтэй, 5 төрлийн 343.2 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 104 ширхэг маягт бичигдсэн боловч холбогдох байгууллага, хүмүүс нь аваагүй, 10 төрлийн 324 ширхэг буюу 577.1 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий маягт хүчингүй болсон байна.

Дээрх маягтуудыг бараа материалын бүртгэлд бүртгэж тайлагнаагүй, яамны Нэг цэгийн үйлчилгээний ахлах мэргэжилтэн хариуцан ажиллаж байна.

Эрсдэлүүд

Үнэт цаас, тооцоот маягтын хадгалалт хамгаалалт, зарцуулалтад бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах, үргүй зардал гаргах;

ҮАГ-ын зөвлөмжүүд

Үнэт цаас, тооцоот маягтыг аж ахуйн нярвын хариуцлагад шилжүүлэн, бараа материалын дансанд бүртгэж, шаардах хуудсаар зарцуулан, тайлан тооцоонд тавих дотоод хяналтын үр нөлөөг сайжруулж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2015 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2015.04.24 № 808

танай _____-ны № _____-т

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН
ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙД Д.ОЮУНХОРОЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А. ЗАНГАД

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,837,246,447.16	969,089,328.13
Кассанд байгаа бэлэн мөнгө	2,504,273.96	234,120.78
Төгрөг\ ЖМС	2,504,273.96	234,120.78
